

ДАРХАН УУЛ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ
ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ТУСГАХ САНАЛ

2023.05.09-ны өдөр

№	Одоо хэрэгжиж байгаа хуулийн заалт	Өөрчлөх санал	Шинээр нэмэх санал
Нэг. Эрүүл мэндийн тухай хууль			
1	3.1.6."эрүүл мэндийн ажилтан" гэж эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бусад ажилтныг;	эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бусад ажилтныг тодорхой задлаж тайлбарлах	
2	8 дугаар зүйл.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх		Эрүүл мэндийн газрын даргыг ЭМЯ-ий шийдвэрээр томилгоожуулах
3	11.3.Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн даргыг тухайн шатны Засаг дарга, аймгийн эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөж томилж, чөлөөлнө. 12.2.Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нь тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж, харьяа нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагын даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.	Утга нэг давхцсан заалт	
4	17.8.2.эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүнийг эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн болон эмнэлгийн мэргэжилтнээс бусад ажилтны төлөөлөл тус бүрээс нэг хүнийг тухайн хамт олны ердийн олонхийн төлөөлөл оролцсон ирцтэй хурлаас нэр дэвшүүлснээр;	эмнэлгийн хамт олныг төлөөлөх дөрөв гишүүнийг эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн болон эмнэлгийн мэргэжилтнээс бусад ажилтны төлөөлөл тус бүрээс нэг хүнийг тухайн хамт олны ердийн олонхийн төлөөлөл оролцсон ирцтэй хурлаас нэр дэвшүүлснээр;	
5			Ангаахын дадлагын оюутан сургалцагчын үүрэг эрх нийтлэг шаардалга сургууль, эмнэлэг хамтын харилцааны хэм хэмжээ тусгах зүйл заалт нэмэх
6	29.2.Төрийн өмчийн эрүүл мэндийн болон бусад салбарын байгууллагад 25 ба түүнээс дээш жил, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтанд тэтгэвэрт гарахад нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндсэн цалингийн дунджаас нь тооцож олгох бөгөөд нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуульд заасан журмыг баримтлан тогтооно.		Энэ заалтыг хэвээр нь үлдээх

7	29.5.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын, аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгоно.	Нарийн журамлах шаардлагатай байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн бус төрийн үйлчилгээний албан хаагч нийтэд хамруулах эмнэлгийн бус мэргэжилтэй, нягтлан, эдийн засагч, аж ахуй албаны ажилтан, хүний нөөц, нарийн бичиг, асрагч нар	Эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байгаа эмнэлгийн бус мэргэжилтнүүдэд тодорой хэмжээнд хамруулах
Хоёр. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль			
1	15.10.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө дараахь үндэслэлээр эгүүлэн татна	Төлөөлөн удирдах зөвлөл гишүүдийг тухайн нэгдсэн эмнэлгийн ажилчид санал хураан эгүүлэн татах эрхтэй байх	
2	16.6.Эмнэлгийн захирал дараахь нийтлэг эрхтэй байна	Нэгдсэн эмнэлгийн дарга нь нийт жилийн эцсийн гүйцэтгэлийг харгалзан нийт ажилчдад урамшуулал болон тухайн жилийн ашгийг хүртээмжтэй байдлаар олгох эрхтэй	
3	16.7.Эмнэлгийн захирал дараахь нийтлэг үүрэгтэй байна	Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй	
4	21.8.Хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, клиник, түргэн тусламжийн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх энэ хуулийн 18.1-д заасан тусламж, үйлчилгээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг нь нэгдсэн эмнэлэгт гэрээлэн ажиллах бололцоог хангах	
5			Инфляцитай уялдуулан Эрүүл мэндийн байгууллагын албан хаагчдын цалинг нэмэгдүүлж байх
6			Эрүүл мэндийн газрын бүтэц орон тоог аймгийн эрүүл мэндийн газрын дарга нарын саналыг үндэслэх

Хуулийн санал нэгтгэсэн

Б.Эрдэнэчимэг (Хуулийн мэргэжилтэн)